



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 04

Мандалговь

Хөрөнгө акталж худалдах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТОХ НЬ:

1. Сайнцагаан сумын "Говийн ирээдүй" цогцолбор сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 9,993,400.00 /Есөн сая есөн зуун ерэн гурван мянга дөрвөн зуун төгрөг/-ний анхны өртөгтэй, 2,165,236.00 /Хоёр сая нэг зуун жаран таван мянга хоёр зуун гучин зургаан төгрөг/-ний үлдэгдэл өртөгтэй 46-16 ДУА улсын дугаартай Mitsubishi Delica маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 2,000,000.00 /Хоёр сая төгрөг/-өөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын "Говийн ирээдүй" цогцолбор сургууль /Э.Дагдан/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



0100206